	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,018,534,400.0</b>	<b>1,009,240,554.00</b>	<b>9,293,846.00</b>	<b>99.09</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>66,993,200.00</b>	<b>65,861,484.00</b>	<b>1,131,716.00</b>	<b>98.31</b>
132001	Орон нутгийн төсвөөс	66,993,200.00	65,861,484.00	1,131,716.00	98.31

1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	863,113,500.00	854,951,370.00	(8,162,130.00)	99.14
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	863,113,500.00	854,951,370.00	(8,162,130.00)	99.14
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>85,908,700.00</b>	<b>85,908,700.00</b>		<b>100.0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	85,908,700.00	85,908,700.00		100.0
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>2,519,000.00</b>	<b>2,519,000.00</b>	-	<b>100.0</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	360,000.00	360,000.00	-	100.0
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,159,000.00	2,159,000.00	-	100.0
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	1,652,000.00	(1,652,000.00)	-
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.0	63,478,499.00	(63,478,499.00)	
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	00.0	00.0	00.0	
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.0	1.0	00.0	
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	35.0	35.0	00.0	
620001	Удирдах ажилтан	01.0	01.0	00.0	
620002	Гүйцэтгэх ажилтан	26.0	26.0	00.0	
620003	Үйлчлэх ажилтан	08.0	08.0	00.0	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Их-Уул сумын ЭМТ нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэдний эрэлт хэрэгцээнд тулгуурлан эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэн тусламж үйлчилгээг аюулгүй, чанартай жигд хүртээмжтэй хүргэх, дундаж наслалтыг уртасгах зорилго тавьсан байна.

Их-Уул сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх үзлэгийг 50-иас дээш хувьд хүргэх
- Эрүүл мэндийн боловсрол олгох
- Тоног төхөөрөмжөөр хангагдах
- Ээлтэй орчин бүрдүүлэх
- Эх хүүхдийн хяналтыг сайжруулах, эндэгдэлгүй ажиллах
- Жирэмсний эрт үеийн хяналтыг 90 хувьд хүргэх

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### *Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн

хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан<sup>1</sup> 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан<sup>2</sup> тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.**

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу ЭМТ-ийн даргын 2022 оны 4 сарын 29-ны өдрийн А/07 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 2 заалт бүхий 7 ажлын хүрээнд графикт хяналт шалгалтыг зохион байгуулж дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. Тухайлбал: Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

<sup>1</sup> “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

<sup>2</sup> “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Их-Уул сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 128,730.8 мянган төгрөгөөр буюу 7.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,652.00	63,478.49	61,826.49
Авлага	85,908.7	0	-85,908.7
Бараа материал	157,317.95	155,365.32	-1,951.63
Үндсэн хөрөнгө	1,504,523.05	1,659,287.68	154,764.63
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,749,400.70</b>	<b>1,878,131.50</b>	<b>128,730.80</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,749,400.70	1,878,131.50	128,730.80
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,749,400.70</b>	<b>1,878,131.50</b>	<b>128,730.80</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө дансуудад өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 61,826.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 1,951.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 154,764.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 258,387.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба төсвийн хөрөнгөөр 16,340.0 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалт болон буцалтгүй тусламжаар 242,047.2 мянган төгрөг байна. Үлдэх өртөггүй ашиглалтын хугацаа болон элэгдэл нь бүрэн дууссан, ашиглах бүрэн боломжгүй болсон 7,118.43 мянган хөрөнгийг акталж, устгаж бүртгэсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 803,037.6 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогоос 130,005.6 мянган төгрөг нийт 933,043.3 мянган төгрөг нийт зарлагыг 933,043.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс зардлыг 47,256.8 мянган төгрөгөөр нэмж, үйл ажиллагааны орлогоос зардлыг 31,277.96 мянган төгрөгөөр бууруулж, нийт 949,022.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг орон нутгийн санхүүжилтээс 4,666.8 мянган төгрөгөөр хасаж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 66,993.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 940,860.1 мянган төгрөгийг улсын төсвөөс орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 940,860.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого төвлөрүүлээгүй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 947,414.1 мянган төгрөг буюу 92.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 72,772.34 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	357,877.80	338,181.19	19,696.61	94.5
2	Үндсэн тусламж үйлчилгээ	495,087.70	443,143.68	51,944.02	89.5
3	Дээд шатны төсвөөс хувиарласан	100,227.70	100,227.70	-	100.00
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	61,660.0	60,528.28	1,131.72	98.3
5	Нийтлэг үйлчилгээ	5,333.20	5,333.20	-	100.00
	Нийт дүн	1,020,186.4	947,414.05	72,772.35	92.87

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар цэвэр бохир усны зардал 1,131.7 мянган төгрөгийн хэтрэлттэй байна. Цэвэр бохир усны хэмнэлт үүссэн шалтгаан нь сард хэрэглэх усыг тогтмол хянаж үргүй зардал гаргахгүй байсантай холбоотойгоор хэмнэлт үүссэн. Орон нутгийн төсөвт 2022 оны 06-р сарын 29-ний өдрийн 02-р тогтоолоор байр ашиглалтын үйлчилгээний зардлаас 4,666.8 мянган төгрөгийн хасах зохицуулалтыг хийсэн. Цалингийн зардал 26,194.9 мянган төгрөг, шимтгэл 6,006.6 мянган төгрөг, нормативт зардал 574.2 мянган төгрөг, дотоод албан томилолт 217.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний төлбөр хураамж 2,409.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал

4,378.6 мянган төгрөгөөр нийт 72,772.3 мянган төгрөгөөр төсвийн зарцуулаагүй үлдэгдэл үүссэн байна.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 85,908.7 мянган төгрөгийн авлага болон эхний үлдэгдэл 1,652.0 мянган төгрөг нийт 87,860.7 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг төрийн сангийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар Шилэн дансны аудиттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,347,064.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 26,941.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 18,858.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 30,008.1 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Их-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага байхгүй, мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар, мөн эмнэлгийн нэрийг шинэчлэх болиогүй 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийн бүрэн биелүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	0	2	0	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эм, тоног төхөөрөмжийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь эм 53,164.2 мянган төгрөг, тоног төхөөрөмж 23,800.0 мянган төгрөг нийт 76,964.2 мянган төгрөгийн тендергүй худалдан авалт хийсэн байна.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 145,014.4 мянган төгрөгийн алдаа<sup>3</sup> илэрснээс аудитын явцад 94,006.6 мянган төгрөгийн алдааг залруулж, 51,007.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 94,006.6 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 8,097.9 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 51,007.8 мянган төгрөгийн зөрчил<sup>4</sup> илэрснээс, 51,007.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

##### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

##### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

##### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Нийгмийн эрүүл мэндийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Нийгмийн эрүүл мэндийн зардлаас 4,645.0 мянган төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна. Энэ нь гаргасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалттай нийцээгүй ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

<sup>3</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>4</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 2. Бараа материалтай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Хүнсний материалыг сарын бодит хэрэглээнээс илүү хэмжээгээр 4,638.6 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1<sup>5</sup> дахь заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Бараа материалыг их хэмжээгээр нөөцөлж, үр ашиггүй зардал гаргахгүй байх

## 3. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 11,716.1 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтад үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж тайлагнах

## 4. Шилэн данстай холбоотой асуудал

### Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ 30,008.1 мянган төгрөгийн 2 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалтыг зөрчсөн байна.

### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
							Залруулсан		Залруулаагүй			
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан	1	85,908.7			1	85,908.7	1	85,908.7				
Эдийн засгийн ангилал буруу сонгосон	1	8,097.9			1	8,097.9	1	8,097.9				
Дүн	2	94,006.6			2	94,006.6	2	94,006.6				

<sup>5</sup> "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийг зориулалтаар зарцуулаагүй	1	4,645.0					1	4,645.0				
Сарын бодит хэрэглээнээс илүү материал нөөцөлсөн	1	4,638.6					1	4,638.6				
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	11,716.1					1	11,716.1				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>20,999.7</b>					<b>3</b>	<b>20,999.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй байна.	1	30,008.1					1	30,008.1
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>30,008.1</b>					<b>1</b>	<b>30,008.1</b>

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:



Х.ДИЙМАА ОГНОО:

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО: